

**БАТЛАВ: ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН
ЗДТГ-ЫН ДАРГА А.БАДАМДОРЖ**

**ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ҮДИЙН ЦАЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮНС ХУДАЛДАН АВАХ АЖЛЫН ТЕНДЕРИЙН
БАРИМТ БИЧИГ**

**Тендер шалгаруулалтын нэр: Төв аймгийн Сүмбэр сумын ЕБС-н үдийн цайны
хүнс худалдан авах ажил
Тендерийн дугаар:ТӨАСҮСЗДТГ/20240102003**

Сүмбэр сум 2024 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Сүмбэр сумын ЗДТГазар] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цайны хоол, хүнс / нийлүүлэх]**-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэх цахим тендер шалгаруулалтад урьж байна.

Үнийн санал ирүүлэх үйлчилгээний зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаас авна уу.

Үнийн саналыг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахимаар хаягаар **[2024 оны 06 дугаар сарын 10-ны 11,00 цаг]**-аас өмнө **[Төв аймгийн Сүмбэр сумын ЗДТГ-т]** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2024 оны 06 дугаар сарын 10 ны өдөр]**-ны өдрийн **[10 цаг 30]**¹-т нээнэ.

*[Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын орлогч,
утас:95956070*

Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
 - 1.2. Тендерт оролцогч тухайн үйлчилгээнд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: **[ТШӨХ-д заасан шалгуур, шаардлагыг бүрэн хангасан байна]**
 - 1.3. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг үйлчилгээ үзүүлэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд: **[тоног төхөөрөмжийг жагсаана]**
2. **Тендерийн иж бүрдэл**
 - 2.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үйл ажиллагааны хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) **[Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]**
3. **Тендерийн үнэ**
 - 3.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт үйлчилгээ хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үйл ажиллагааны хуваарьт үндэслэнэ.
 - 3.2. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон үйл ажиллагааны хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 3.3. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
4. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 4.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **[45]^р** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

5. Алдааг залруулах

- 5.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна

- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ
 - (б) үйл ажиллагааны үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үйл ажиллагааны үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг үйлчилгээний тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 5.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 6. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 6.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 6.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 7. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 7.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах “Хүнсний эрхийн бичгийн” талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа /ТӨӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүй
ТӨӨЗ 1.1	Захиалагч нь: [Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын Газар]
ТӨӨЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цайны хоол, хүнс нийлүүлэх]
ТӨӨЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Үүнд: ТӨАСҮСЗДТГ/20240102003
ТӨӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: [Улсын төсвийн урсгал зардал 37.729.800 төгрөг] төгрөг
Б. Тендерийн баримт бичиг	
ТӨӨЗ 8.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: [Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар Засаг даргын орлогч утас: /95956070]
ТӨӨЗ 8.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын [0] хоногоос багагүй байна. Тодруулга шаардлагагүй
В. Тендер бэлтгэх	
ТӨӨЗ 11.1	Хэрэв тендерт гадаадын этгээд оролцох эрхтэй бол тендерийн хэл нь [Гадаадын этгээд оролцох эрхгүй.]
ТӨӨЗ 12.1 (a)– (è)	1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /тендер зарласнаас хойш тендер хүлээн авах хүртэлх хугацаанд нотариатаар баталгаажуулсан байх/ 2. Шаардлагатай гэрчилгээ, зөвшөөрлийн хуулбаруудыг нотариатаар баталгаажуулан ирүүлэх 3. Оролцогч компаний танилцуулга 4. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл, 5. Тендерт оролцогчийн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл 6. Харьяалагдах банкуудын тодорхойлолт тендер зарласнаас тендер хүлээн авах

хүртэлх
хугацаагаар
авсан байна.
7. Шүүхийн
шийдвэр
гүйцэтгэх
газрын
тодорхойлолт
/эх хувь/
тендер
зарласнаас

	<p>тендер хүлээн авах хүртэлх хугацаагаар авсан байна.</p> <p>8. Татварын газрын тодорхойлолт -татварын цахим тайлангийн системээс авсан бар код бүхий тодорхойлолт , / тендер зарласнаас тендер хүлээн авах хүртэлх хугацаагаар авсан байна. Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх.</p> <p>9. Татвар, Нийгмийн даатгалын хэлтэс, харилцагч банкуудаас тодорхойлолт , лавлагаа авахад татгалзах зүйлгүй талаархи мэдэгдэл ирүүлэх.</p> <p>10. Гэрээний ерөнхий болон Тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч буй эсэх тухай мэдэгдэл</p> <p>11. ТШӨХ-д заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно</p>
ТӨӨЗ 12.2	<p>1. Тендерийн материалын үнийн саналыг загвар маягтын дагуу бэлтгэж тендерт оролцогчийн тамга, эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан ирүүлнэ. Цахим системээр давхар ирүүлсэн байна.</p> <p>2. Үнийн саналын маягтад тусгагдсан нийт дүнгийн тоо нь тухайн тендерийн санал болгож буй үнэ байна. /Санал болгосон үнэнд НӨАТ, татвар, хураамж бүгд багтсан байх бөгөөд нийт үнийн саналд дээрх татвар, хураамж багтсан гэж үзнэ./</p>
ТӨӨЗ 14.1	Хувилбарт тендер ирүүлэхийг <i>[зөвшөөрөхгүй]</i> .
ТӨӨЗ 15.9 (а)	“Бараа хүргэгдэх эцсийн цэг (Захиалагчийн агуулах, эсхүл барааг эцсийн хэрэглэгчид хүргэх байршил)”: ЕБСургуулийн склад
ТӨӨЗ 15.10	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <i>[тохируулахгүй тогтмол байна.]</i>
ТӨӨЗ 16.1	Тендерийн валют: <i>[Төгрөг байна.]</i>
ТӨӨЗ 18.1 (а)	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: <i>[“шаардлагатай”]</i>
ТӨӨЗ 18.1 (б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 1 <i>[2020 оны санхүүгийн тайлан баланс ирүүлнэ. Нотариатаар батлуулсан байна].</i>
ТӨӨЗ 18.1 (г)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 1 <i>[Сүүлийн 1 жилийн буюу 2023 онуудын аль нэг ижил төстэй бараа нийлүүлсэн байна.]</i>
ТӨӨЗ 18.1 (д)	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: <i>[шаардлагатай] Хэрэв барааг захиалагчид өөрийн байранд хүргэж өгөөгүй, хуваарийн дагуу нийлүүлээгүй, бүтээгдэхүүний хоцрогдол, тасралт үүсгэсэн тохиолдолд гэрээний үүргээ зөрчсөнд тооцож “Хар жагсаалт”-д орох нөхцөл үүсэх болохыг анхаарах.</i>
ТӨӨЗ 18.2 (а)	Борлуулалтын хэмжээ: <i>[шаардахгүй]</i>
ТӨӨЗ 18.2 (б)	Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 1 <i>[Сүүлийн жилийн мэдээлэл ирүүлнэ.]</i>

ТОӨЗ 18.2 (в)	Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: [Шаардлагатай] <i>Бараа бүтээгдэхүүн нийлүүлэх автомашины фото зураг ирүүлэх</i>
ТОӨЗ 18.2 (г)	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 10 хувиас багагүй байх
ТОӨЗ 18.2 (д)	Ашигтай ажилласан байх жилийн тоо: [2023 онд ашигтай ажилласан байна.]
ТОӨЗ 18.2	Тендерт оролцогчийн гэрээг хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт: Дараах баримт бичгүүдийг тендерт заавал хавсаргана. <i>Тендер нь шалгарсан тохиолдолд тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэхэд дараах нөхцөл байдлыг нотлох баримт бичиг шаардагдана:</i> <i>(i) Хэрэв тендерт оролцогч нь гэрээний дагуу өөрийн үйлдвэрлэсэн барааг нийлүүлж буй бол:</i> (а) тендерт оролцогч нь бараа үйлдвэрлэгдсэн улсад үйл ажиллагаа явуулдаг; (б) тухайн орны эрх бүхий байгууллагаас тухайн барааг нийлүүлэх эрхийг авсныг; (в) тендерийн баримт бичигт заагдсан үйлчилгээг 2-оос доошгүй жил, ижил төрлийн барааг 5-аас доошгүй жил үйлдвэрлэж, борлуулсныг; <i>(ii) Хэрэв тендерт оролцогч нь нийлүүлж буй бараагаа өөрөө үйлдвэрлээгүй бол,</i> (а) Тендерт оролцогч нь барааг нийлүүлэх зөвшөөрлийг үйлдвэрлэгч эсхүл гэрээт борлуулалгчаас албан ёсоор авсан буюу Монгол улсад тухайн барааг нийлүүлэх шалгууруудыг хангасныг;
ТОӨЗ 19.1 (б)	Барааг тасралтгүй горимын дагуу ашиглах, эсхүл ажиллуулахаар тооцоолж буй хугацааны үе (энэ хугацаанд шаардагдах сэлбэг хэрэгслийг тооцоолох зорилготой): Тендерт оролцогчийн гэрээний дагуу нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх үйлчилгээ нь захиалагчийн шаардлагад нийцсэн байна.
ТОӨЗ 20.1	Тендер нээснээс хойш 10 хоногийн туршид хүчинтэй байна.
ТОӨЗ 21	Тендерийн баталгааны үнийн дүн: Шаардахгүй
ТОӨЗ 22.1	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: [0%]
Г. Тендер ирүүлэх	
ТОӨЗ 23.3 (б)	Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь:
	Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч

	нь цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.
ТӨӨЗ 23.3 (в)	Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: [Сумын Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цайны хоол, хүнс нийлүүлэх] ТӨАСҮСЗДТГ/202101030 <i>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ.</i>
ТӨӨЗ 24.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: [2024 оны 06 дугаар сарын 10 -ны өдөр] Цаг: [11 цаг 00 минут] тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирсэн материалыг хүлээн авах боломжгүй.
Д. Тендерийг нээх, үнэлэх	
ТӨӨЗ 28.1	Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: [Төв аймгийн Сүмбэр сумын ЗДТГ-т] Давхар болон өрөөний дугаар: [тоот] Аймаг, хот: [Төв аймаг, Сүмбэр сум] Улс: [“Монгол Улс”] Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: [2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр] Цаг: [11 цаг 30 минут]
Е. Гэрээ байгуулах эрх олгох	
ТӨӨЗ 40.1	Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: [25%] Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: [25%]

ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ БА ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВААРЬ

“Энэхүү хүснэгтийг захиалагч бөглөнө үйлчилгээг гүйцэтгэж дуусах хугацааг аль болох бодитой байхаар тооцож, бараа нийлүүлэх хугацаатай уялдуулан тогтооно.”

Сүмбэр сумын ЕБСургуулийн үдийн цайны барааны жагсаалт

БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ

Огноо: _____

(А ангилал)

НТШ-ын дугаар: _____

Тендерийн урилгын дугаар: ____

Хувилбарт тендерийн дугаар: _____

Хуудасны ____ -ын ____ дугаар ____

ТООЗ-ны 16-д заасан валютаар

	1	2	3	4	5	6	7
	Хүнсний бүтээгдэхүүн	Хэмж их нэгж	Нийт хэмжээ	Захиалагчийн нэгжийн үнэ	Захиалагчийн нийт үнэ	Тендерт оролцогчийн үнэ	Тендерт оролцогчийн нийт үнэ
	БАГЦ-1						
Гурил. Будаа гурилан	Гурил /дээд/	кг	630	2200	1386000		
	Цагаан будаа	кг	300	4000	1200000		
	Гурвалжин будаа	кг	100	7000	700000		
	Ургамлын тос	кг	180	10000	1800000		
	Цайны идээ	кг	20	3500	70000		
	Элсэн чихэр	кг	80	4000	320000		
	Нарийн гоймон	ш	80	4000	320000		
	Мушгиа гоймон	кг	50	4000	200000		
	Майонез	ш	20	11000	220000		
	Масло	хайрц аг	25	14000	350000		
	Үзэм	кг	60	10000	600000		
Хар чавга	ш	70	18500	1295000			

бүтээгдэхүүн, хольц	Нэрс шүүс	уут	25	15000	375000		
	Аньс шүүс	уут	25	15000	375000		
	Үхрийн нүдний шүүс	ш	25	15000	375000		
	Шөлний байцай	ш	25	6500	162500		
	Сода	кг	30	3000	90000		
	Лимоны хүчил	ш	10	2500	25000		
	Мөөг	ш	10	13000	130000		
	Шпагетин гоймон	ш	100	6700	670000		
	Овьёос хэмхдэс	ш	29	2500	72500		
	Каша/Хүүхдийн будаа/	ш	20	4500	90000		
	Чинжүү	ш	80	9000	720000		
	Броклер	ш	28	9000	252000		
	Давс	кг	30	2500	75000		
	Чиколай	кг	1000	650	650000		
	Алим	ш	90	8500	765000		
Гоньд	кг	10	1600	16000			
Далайн байцай	кг	60	4000	240000			
Зөөхий	кг	40	5000	200000			
	Сармис		60	3500	210000		
	Оливнын тос		4	20000	80000		
Багц 1-н дүн					14,034,000.00		
БАГЦ-2							
Мах, сүү сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногоо /дотоодын	Төмс	кг	1450	1500	2175000		
	Байцай	кг	501	2800	1402800		
	Шар манжин	кг	250	3000	750000		
	Хүрэн манжин	кг	80	3000	240000		
	Лууван	кг	200	3000	600000		
	Сонгино /монгол/	кг	70	3500	245000		
	Үхрийн мах	кг	1000	13000	13000000		

үйлдвэрий н бүтээгдэх үүн/	Хонины мах	кг	300	11000	3300000		
	цөцгий	кг	30	8000	240000		
	Аарц	кг	250	6000	1500000		
	Сүү	кг	81	3000	243000		
Багц 2-н дүн					23,695,800		
Нийт дүн					37,729,800.00		

1.Техникийн тодорхойлолт

ЕБСургуулийн үдийн цай хөтөлбөрт шаардагдах хүнсний бүтээгдэхүүн нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандарт, шаардлагад нийцсэн байна.

№	Хүнсний бүтээгдэхүүний нэр , төрөл	Тодорхойлолт
Гурил , будаа, гурилан бүтээгдэхүүн хольц	1-р гурил	Дотоодод үйлдвэрлэсэн 1-р зэргийн гурил, найрлага чанарын хувьд 25 кг-р савласан байх
	Бүхэл үрийн гурил	Чанарын шаардлага хангасан 1кг-р савлагдсан бүтээгдэхүүн байх
	Каша/хүүхдийн будаа/	Сайн чанарын эрүүл ахуй, ариун цэврийн стандарт шаардагад нийцсэн 1кг савласан бүтээгдэхүүн
	Цагаан будаа	Цагаан будаа нь Стандартад нийцсэн чийг 15%-иас ихгүй,хэвийн үнэртэй,гадны амт үнэргүй зуйван дугуй хэлбэртэй 5 кг савласан байх MNS ISO7301 : 2000
	Гурвалжин будаа	Гурван талт самранцар үртэй байна.Дотоодод үйлвэрлэсэн 1кг савласан байх MNS 5272 : 2003
	Арвайн гурил	Дотоодод үйлдвэрлэсэн, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн байна. 1кг савлагаатай
	Лавшаа гоймон	Чанарын шаардлага хангасан.Алтан тариан гоймонтой дүйцхүйц 5кг хүртэл савлагаатай MNS 0142 : 1985
	Мушгиа гоймон	
	Шпагет гоймон	
	Пүнтүүз	Хаяг шошго стандарт шаардлага хангасан 1 кг савласан
	Элсэн чихэр	Хүнсний аюулгүй байдлыг хангасан зориулалтын савлагаатай 5 кг хүртэл савласан MNS CAC 4: 1995
	Ургамлын тос	Стандартын сав боглоотой, нэр төрөлдөө тохирсон өнгөтэй MNS CAC 23 : 1998
	Хуурай цай	Дугуй булант, болон хадагтай цайны төрөл сайн чанарын, эрүүл ахуйн,ариун цэврийн стандарт шаардлагад нийцсэн MNS 5864 : 2008
	Молоко	Оросын холбооны улсад үйлдвэрлэсэн сайн чанарын бүтээгдэхүүн байна.
	Масло	Сайн чанарын эрүүл ахуй, ариун цэврийн стандарт шаардагад нийцсэн бүтээгдэхүүн MNS ISO 1740-2000
Майноз	Албан ёсны стандарт шаардага хангасан бүтээгдэхүүн байх	
Хүүхдийн будаа	Шар өнгөтэй, нэгэн жигд нарийн ширхэгтэй хуурай, нунтаг, гадны механик хольцгүй 1 кг савласан байх	
Хөц будаа	Стандартад нийцсэн, чийг 15%-иас ихгүй, хэвийн үнэртэй, гадны амт үнэргүй 1кг савласан байх	

	Шар будаа	Стандартад нийцсэн, чийг 15%-иас ихгүй, хэвийн үнэртэй, гадны амт үнэргүй 1кг савласан байх
	Цагаан давс	Эх оронд үйлвэрлэгдсэн сайн чанарын иоджуулсан давстай дүйцэхүйц, сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн 1кг савласан
	Цайны печень Коровка печень Джек	Сайн чанарын эрүүл ахуй, ариун цэврийн стандарт шаардагад нийцсэн. Орос улсад үйлдвэрлэсэн MNS 0158 : 1985
	Кетчуп,Цууны хүчил	Сайн чанарын эрүүл ахуй,ариун цэврийн стадарт шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн
	Сода , хөөлгөгч , амтлагч,лаврын навч,ёотон	Олон улсын стандартад нийцсэн. Хүнсэнд хэрэглэгдэх зориулалттай орос улс ба эх оронд үйлдвэрлэсэн MNS 0356 : 1989
Төмс , хүнсний ногоо жимс , жимс	Төмс	Нийлүүлэх төмс нь орон нутагт тариалагдсан. Хадгалалтын чанарын шаардлага хангасан, ялзарч муудаагүй. Ширхэг нь 50 г –с доошгүй жинтэй, 1-р зэргийнх байна.MNS 0258 : 2006
	Байцаа	Монголд улсад тариалагдсан. Хадгалалтын чанарын шаардлага хангасан, стандарт шаардлага хангасан 1-р зэргийнх байна.MNS 0255 :200
	Лууван,Чинжүү	Монголд улсад тариалагдсан. Стандарт шаардлага хангасан 1-р зэргийнх байна.MNS 0270 : 1982 чинжүү MNS 0279 : 1982
	Сонгино, Помидор	Стандарт шаардлага хангасан 1-р зэргийнх байна MNS 0260 :1982
	Сармис	Стандарт шаардлага хангасан 1-р зэргийнх байна MNS 0267-197
	Хүрэн манжин,Манжин	Монголд улсад тариалагдсан. Стандарт шаардлага хангасан 1-р зэргийнх байна.MNS 0258 : 2006
	Жимсний варень	Стандартын шаардлага хангасан хадгалалтын горим, хугацаа зөрчөөгүй, хөлдөөгүй /нэрсний чанамал, гүзээлзгэний чанамал,үхрийн нүдний чанамал,гэх мэт/ бүтээгдэхүүн байна
	Чацаргана Аньс	Сайн чанарын эрүүл ахуй, ариун цэврийн стандарт,шаардагад нийцсэн.Гадаад байдал амт ба үнэр боловсролт зэргийг баримталсан байна. Монголд ургадаг / Нэрс , аньс , чацаргана, хад , үхрийн нүд гэх мэт / аль ч байж болно./ хүнсний шинжилгээний бичигтэй/MNS-046219
	Соус, томота	Сайн чанарын эрүүл ахуй, ариун цэврийн стандарт шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн
	Чацарганы шүүс, нэрсний жүүс	Сайн чанарын эрүүл ахуй, ариун цэврийн стандарт шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн

	Далайн байцаа	Сайн чанарын эрүүл ахуй, ариун цэврийн стандарт шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн MNS ISO 4125-2000
	Алим	Сайн чанарын эрүүл ахуй, ариун цэврийн стандарт шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн MNS CAC 299
	Тарвас,Банана, Өргөст хэмх	Сайн чанарын эрүүл ахуй, ариун цэврийн стандарт шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн MNS CAC 115 :1995
	Үзэм , чавга	Орос улсад үйлвэрлэсэн.Сайн чанарын,эрүүл ахуй,ариун цэврийн стандарт шаардлагад нийцсэн. 1-5 кг-р савласан, хадгалалтын хугацаа горим зөрчөөгүй байх
Мах болон, сүү, сүүгн бүтээгдэхүүн	Үхрийн мах	Эрүүл ахуй, ариун цэврийн стандартад нийцсэн гарал үүслийн гэрчилгээ, шинжилгээний бичиг бүхий 1-р зэргийн, хадгалалтын горим зөрчөөгүй, муудаж хуучраагүй байх MNS5023-2001 ,MNS1111-2007
	Зөөхий	Эрүүл ахуй,ариун цэврийн стандартад шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн
	Тараг	Хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан цех үйлдвэрт хийгдсэн, чанарын баталгаатай, 0,24л савлагаатай, хүүхэд шууд ууж хэрэглэх шинэ бүтээгдэхүүн байна.
	Сүү	Сүү сүүн бүтээгдэхүүн нь хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан, шинэ, орон нутгийн гарал үүслийн бичигтэй /Гарал үүслийн бичигт малчны тамгаар баталгаажсан байх/ MNS 4228 : 2011 ,MNS CACA 11Б : 1998 ,MNS 4081 : 1988
	Аарц	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**
1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8

Тендерийн нийт үнэ

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Гурав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

А. ЕРӨНХИЙ ЗААЛТ

1. **Гүйцэтгэгч үйлчилгээ үзүүлэх**
 - 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан үйлчилгээг техникийн тодорхойлолт болон хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ.
2. **Төслийн менежерийн шийдвэр**
 - 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлсөн менежер шийдвэрлэнэ.
3. **Үйлчилгээ дуусгахаар төлөвлөсөн өдөр үйлчилгээ дууссан байх**
 - 3.1. Гүйцэтгэгч үйлчилгээг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан үйл ажиллагааны хуваарь болон төслийн менежерийн баталсан тодотгосон үйл ажиллагааны хуваарийн дагуу хийж гүйцэтгэн, үйлчилгээ дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. **Аюулгүй байдал**
 - 4.1. Гүйцэтгэгч бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна.
 - 4.2. Үйлчилгээ үзүүлэхэд байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь үйлчилгээтэй холбогдуулж байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. **Зааварчилгаа**
 - 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй.
6. **Маргааныг шийдвэрлэх**
 - 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

7. **Үйл ажиллагааны хуваарь**
 - 7.1. Гүйцэтгэгч нь үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан үйл ажиллагааны хуваарийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
 - 7.2. Үйл ажиллагааны хуваарийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь үйл ажиллагааны хуваарийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. **Зөрчил, гологдол илрүүлэх**
 - 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн үзүүлсэн үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил,

- гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа үйчилгээнд зөрчил, гологдол хайх, далд хэсгийг нээж шалгалт, түршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
- 9. Зөрчил, гологдол арилгах**
- 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа³ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үйл ажиллагааны хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үйл ажиллагааны хуваарийн тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үйл ажиллагааны хуваарь нь үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үйл ажиллагааны хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үйл ажиллагааны хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр үйлчилгээний арга барил, эсхүл үйл ажиллагааны хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үйл ажиллагааны хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үйл ажиллагааны хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги⁴ төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Үйлчилгээ дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь үйлчилгээ дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер үйчилгээ дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш

³ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хуулийг баримтална.

⁴ Алдангийг ихэвчлэн хоногт 0,05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Гэрээг цуцлах** 17.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 17.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:
- (а) Үйл ажиллагааны хөтөлбөрт үйлчилгээ зогсоох тухай заагаагүй, түүнчлэн үйлчилгээ зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч үйлчилгээг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер үйлчилгээний явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) захиалагч төслийн менежерийн гаргасан төлбөрийн мэдэгдлийн дагуу төлөх төлбөрийг уг мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш 48 хоногийн дотор төлөөгүй;
 - (д) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (е) гүйцэтгэгч үйлчилгээний гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 17.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч үйлчилгээг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 18. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр** 18.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн үйлчилгээний болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй үйлчилгээний гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй. Хэрэв захиалагчид төлөх төлбөрийн нийт дүн гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хэтэрвэл, хэтэрсэн дүн нь гүйцэтгэгчээс захиалагчид төлөх ёстой өр болно.

**19. Гүйцэтгэлээс
чөлөөлөх**

- 18.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн үйлчилгээ болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, үйлчилгээний зорилгоор хөлслөн ажиллүүлсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 19.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйлчилгээг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн үйлчилгээ болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн үйлчилгээний хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Дөрөв. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ⁵

- 2.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: ТӨАСҮСЗДТГ/202101030
- 2.1 Ажил нь [Сумын Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цайны хоол, хүнс нийлүүлэх]-аас бүрдэнэ.
Ажлын талбай нь [Төв аймгийн Сүмбэр]-д байрших
- 3.1 Төслийн менежер нь [Сүмбэр сумын ЗДТГазар 1-р баг]
- 4.1 Ажил эхлэх өдөр [2021, 09 сар]
Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр [2021.10 сар14]
- 7.1 Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын [5] хоногийн дараа гэрээ байгуулна..
- 9.1 Чанарын баталгаат хугацаа [365] хоног байна.
- 13.1 Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [0,05] байна.⁶
Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [10] байна.
- 17.1 Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [шаардлагагүй]-ны дотор гаргаж өгнө.
Гүйцэтгэлийн зургийг [шаардлагагүй]-ны дотор гаргаж өгнө.
Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [мөнгөн дүн] байна.
- 19.1 Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [хувь]-иар тооцно.

⁵ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁶ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

2. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

_____ (Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож оны

___ сарын ___-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс :
Улсын төсвөөс: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг;
Орон нутгийн төсвөөс: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг;
Өөрийн хөрөнгө: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг.
4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай /_____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хүчилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг”

гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Үнийн санал;

Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт;
Зураг;
Гүйцэтгэчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь⁷;
Санхүүжилтийн хуваарь;
Ажил гүйцэтгэх хуваарь;
Бусад шаардлагатай баримт бичиг⁸.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

2. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
3. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
4. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
5. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

⁷ Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарь” гэснийг “ажлын тоо хэмжээ” гэж солино.

⁸ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.